



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.

АУДИТЫН НЭР: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалт
АУДИТЫН КОД: БӨА-2025/27-2-ШТА-ГА

Өлгий хот

2025 оны 6-8
дугаар сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@yahoo.com
Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn
Аудитор: М.Айнур Утас:99423031 Цахим хаяг: Ainurm@audit.gov.mn
Аудитор: Р.Баярмаа Утас:99265539 Цахим хаяг: Bayarmaar@audit.gov.mn
Аудитор: Ш.Нурлан Утас:99422966 Цахим хаяг: NurlanSH@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёог	5
Графикийн товъёог.....	5
Хавсралтын товъёог:	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
Ерөнхий мэдээлэл	8
БҮЛЭГ 1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ БАЙНА	9
А.1. Хуульд заасны дагуу торгуулийн орлогыг төлөвлөсөн нь хэрэгцээ шаардлагад нийцэж байна.	9
А.2. Торгуулийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс 2023, 2024 онуудад тасарсан байна	10
А.2.1. Торгуулийн орлогын төлөвлөгөө нь өмнөх жилүүдэд биелэгдэж ирсэн боловч 2023 онд 185.9 сая төгрөгөөр, 2024 онд 1,055.1 сая төгрөгөөр тасарсан байна.....	10
А.2.2. Торгуулийн орлогыг суурь судалгаа, эрх бүхий байгууллагуудаас авсан тоо хэмжээний мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөж байна.....	11
А.2.3. Хүүгийн орлого төлөвлөөгүй байна.....	12
А.2.4. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолж, төлөвлөж ирсэн байна.	12
А.2.5. Торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлт өгч ажилласан байна	12
А.3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА	13
А.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэхтэй холбоотой хуулийн зарим заалтууд уялдаагүй байна	13
А.3.3. Орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх хуулийн тодорхойгүй маргаантай заалтууд байна	13
А.3.4.Үйлсэн зөрчилд харилцан адилгүй торгууль оногдуулжээ	14
А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна	14
БҮЛЭГ 2. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	16
Б.1. Ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна	16
Б.1.1. Ногдуулсан торгуулийн орлогоос 2024 оны эцсийн байдлаар 3 байгууллага 468.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна	16
Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан байна	18
Б.1.3. Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгаж тайлагнасан байна.....	18
Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт голлох нөлөөг үзүүлж байна.....	18
Б.2. Зарим сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зардал хуваарилаагүй байна.	20
Б.2.1. Төсөв хуваарилах эрх бүхий зарим байгууллага бүрэн эрхээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна	20
Б.2.2. Зарим сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зардал хуваарилж батлаагүй байна.....	20
Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.	22
В.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна	23
В.1.2. Торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулаагүй байна	24
В.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байна	24
В.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж байна.	26
В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна	27
В.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байна.....	27
В.2.2. Торгуулийн орлогын зарцуулалтын тайланг олон нийтэд мэдээлж иржээ.	27
В.2.3 Торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд оролцогч талуудаас үнэлгээ өгөөгүй байна.....	28

бүлэг 4. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан БҮРДЭЭГҮЙ.....	29
Г.1.1 Байгууллагуудын хооронд мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна	29
Г.1.2. Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна	30
Г.1.3. Нэгдсэн хяналтын систем бүрдээгүй байгаа нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна	31
Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна	31
Г.2.1.Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулалт хангалтгүй байна	31
Г.2.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт хэрэгжүүлээгүй байна	32
Г.2.3 Орлого төвлөрүүлэгч зарим байгууллагууд нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна	32
Г.2.4. Хөндлөнгийн байгууллагуудаас торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна	33
ДҮГНЭЛТ:	34
5.Хүү, торгуулийн орлого бүрдүүлэхтэй холбоотой хуулийн зарим заалтууд уялдаагүй байна	34
6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна	34
ЗӨВЛӨМЖ:	35

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Хүснэгтийн товъёог

Хүснэгт 1	Орон нутгийн нийт орлого ба торгуулийн орлогын төлөвлөлт	
Хүснэгт 2	Аймаг, сумын торгуулийн орлогын төлөвлөлт	
Хүснэгт 3	2021,2022 оны торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	
Хүснэгт 4	Татварын бус орлогод торгуулийн орлогын эзлэх хувь хэмжээ	
Хүснэгт 5	Сумуудын 2023,2024 оны торгуулийн орлогын гүйцэтгэл	
Хүснэгт 6	Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлт	
Хүснэгт 7	Торгуулийн орлогын үлдэгдэл, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байдал	
Хүснэгт 8	Торгуулийн орлогын үлдэгдэлийн судалгаа	
Хүснэгт 9	Торгуулийн орлогын үлдэгдэлтэй байгууллагуудын судалгаа	
Хүснэгт 10	Торгуулийн орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь	
Хүснэгт 11	Аймаг болон сумдын 2023-2024 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн төлөвлөгөө	
Хүснэгт 12	Өмнөх онд төвлөрсөн торгуулийн орлого болон 2023-2024 онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн төлөвлөгөө	
Хүснэгт 13	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, зарцуулалт	
Хүснэгт 14	Цагдаагийн газрын бэлэн бус торгууль төлсөн хэлбэр	

Графикийн товъёог

Хавсралтын товъёог:

Хавсралт №01	Торгуулийн орлогын нэгтгэл	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, **2023, 2024** онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулсан. Аудитаар ... байгууллагын холбогдох мэдээ, судалгааг авч нэгтгэсэн.

Аудитын хязгаарлалт

Үгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан

	Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашигласан.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Женисбек хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор М.Айнур, Р.Баярмаа, Ш.Нурлан, Б.Галымбек нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 08 дугаар сарын 04-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны хооронд бэлтгэн тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүллээ.
Аудитын дүн	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар 5 байгууллагад 6 зөвлөмж өгсөн.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт "... хүү, торгуулийн орлого" нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч "хүү, торгуулийн орлого" гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Аймгийн Төсвийн орлогын ангиллыг гүйцэтгэлээр 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Төсвийн орлогын ангилал

Орлогын үзүүлэлт	Сая төгрөгөөр	
	Орон нутгийн төсөвт	
	2023 он	2024 он
Татварын орлого	18,548.90	33,641.20
Татварын бус орлого	2,362.40	2.821.9
Хүү, торгуулийн орлого	974.2	1,175.00

Эх сурвалж: Аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 41.2-41.6 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Хүү, торгуулийн орлого 2023 онд 974.2 сая төгрөг байсан бол 2024 онд 1,175.0 сая төгрөг болж 20.6 хувиар өссөн байна.

БҮЛЭГ 1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ БАЙНА**А.1. Хуульд заасны дагуу торгуулийн орлогыг төлөвлөсөн нь хэрэгцээ шаардлагад нийцэж байна.**

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн зүйлийн 23.1¹-д зааснаар төсвийн орлогын нэг бүрэлдэхүүн хэсэг нь татварын бус орлого ба”, хуулийн 23.3²-т татварын бус орлого нь торгуулийн орлогоос бүрдэнэ гэж заажээ.

Хуулийн 23.72, 23.9.2-дах зүйлд аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлогоос бүрдэнэ гэж заасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1³-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх талаар хуульчилсан.

Автозамын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁴, 25.2.4⁵-д авто замын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулиас авто замын сангийн хөрөнгийг бүрдүүлэхээр хуульчилсан.

Дээрхи хууль тогтоомжуудад заасны дагуу орон нутгийн төсвийн суурь орлогын татварын бус орлогын бүрэлдэхүүнд торгуулийн орлогыг төлөвлөж байна.

Баян-Өлгий аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь орлогын 5.6 хувийг буюу 1,160.1 сая төгрөгийг, 2024 оны орлогын 5.6 хувийг буюу 2,230.7 сая төгрөгийг торгуулийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Хүснэгт№1 Орон нутгийн нийт орлого ба торгуулийн орлогын төлөвлөлт

сая төгрөгөөр

ОН	Төлөвлөгөө		
	Орон нутгийн нийт орлого	Торгуулийн орлого	Эзлэх хувь
2023 он	20,620.4	1,160.1	5.63
2024 он	39,825.8	2,230.6	5.60

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23.1. Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.3-т “Татварын бус орлого нь торгуулийн орлого, болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ”

23.3. “Татварын бус орлого нь торгуулийн орлого, болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ”

46.1. “..... заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ”

25.2. “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ”,

25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд торгуулийн орлогыг аймаг, сум бүрээр баталж ирсэн байна.

Торгуулийн орлогыг төлөвлөсөн байдлыг аймаг, сумаар авч үзэхэд:

Хүснэгт№2 Аймаг, сумын торгуулийн орлогын төлөвлөлт

сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	Торгуулийн орлогын төлөвлөгөө		Зөрүү
		2023 он	2024 он	
1	Алтай	7.3	7.3	-
2	Алтанцөгц	7.3	7.3	-
3	Баяннуур	14.1	27.3	13.2
4	Бугат	24.3	7.3	- 17.0
5	Булган	7.3	7.3	-
6	Буянт	7.3	7.3	-
7	Дэлүүн	7.3	7.3	-
8	Ногооннуур	7.5	7.3	- 0.3
9	Сагсай	7.3	5.7	- 1.6
10	Толбо	7.3	14.8	7.6
11	Улаанхус	20.3	37.3	17.0
12	Цэнгэл	12.3	43.3	31.0
13	Цагааннуур	18.0	25.0	7.0
14	Өлгий	800.0	839.3	39.3
15	Аймаг	213.0	1,187.4	974.4
	Дүн	1,160.1	2,230.6	1,070.6

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Торгуулийн орлогын 2024 оны төлөвлөгөөг 2023 оны төлөвлөгөөгтэй харьцуулахад 1,070.6 сая төгрөгөөр буюу 92.2 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Бугат, Ногооннуур, Сагсай сумууд 0.3 саяаас 17.0 сая төгрөг хүртэл бууруулж төлөвлөсөн бол Баяннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл, Цагааннуур, Өлгий сумууд 7.0 саяаас 39.3 сая төгрөгөөр, Татварын хэлтсийн торгуулийн орлогын төлөвлөгөөг 974.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

А.2. Торгуулийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс 2023, 2024 онуудад тасарсан байна

А.2.1. Торгуулийн орлогын төлөвлөгөө нь өмнөх жилүүдэд биелэгдэж ирсэн боловч 2023 онд 185.9 сая төгрөгөөр, 2024 онд 1,055.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Торгуулийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг судалж үзэхэд 2021 онд 97.3 сая төгрөгөөр, 2022 онд 103.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн ба 2023, 2024 онд өмнөх оны түвшнээс 55 хувь хүртэл нэмэгдүүлэн төлөвлөснөөс торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Хүснэгт№3 2021,2022 оны торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая төгрөгөөр

Он	Төл	Гүй	Зөрүү
2021	517.0	614.3	97.3
2022	744.8	848.3	103.50

Эх сурвалж: Аудитын судалгаа

А.2.2. Торгуулийн орлогыг суурь судалгаа, эрх бүхий байгууллагуудаас авсан тоо хэмжээний мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөж байна

Торгуулийн орлогыг төлөвлөхдөө тоо хэмжээний үзүүлэлтэд үндэслэн төлөвлөсөн байна. Суурь судалгаа буюу өмнөх онуудын төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээний дүнг үндэслэн төлөвлөж ирсэн байна.

Эрх бүхий байгууллагуудаас авсан торгуулийн орлогын төвлөрүүлэлт, үлдэгдэл, авлага, өр, төлбөрийн талаар мэдээлэл судалгааг үндэслэж төлөвлөлтийг хийж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т "Татварын бус орлого нь, торгуулийн орлого, болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ" гэж заасан. Торгуулийн орлогын татварын бус орлогод эзлэх хувийг судалж үзэхэд 2021 онд татварын бус орлогын 41 хувийг, 2022 онд 33 хувийг, 2023 онд 55 хувийг, 2024 онд 62 хувийг торгуулийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 2021, 2022 оны хэрэгжилт 102.4-136.4 хувь бол 2023, 2024 онуудад 74.5-95.1 хувийн гүйцэтгэлтэй ба энэ нь торгуулийн орлого тасарсантай холбоотой байна.

Хүснэгт№4 Татварын бус орлогод торгуулийн орлогын эзлэх хувь хэмжээ сая төгрөгөөр

№	Үзүүлэлт		Төлөвлөгөө			
			2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Татварын бус орлого	төл	1,250.7	2,271.0	2,121.2	3,595.9
		гүй	1,472.4	1,874.0	2,362.4	2,821.9
2	Хүү, торгуулийн орлого	төл	517.0	744.7	1,160.1	2,230.7
		гүй	614.3	848.3	974.2	1,662.4
3	Эзлэх хувь (2/1)	төл	41%	33%	55%	62%
		гүй	42%	45%	41%	59%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хүү, торгуулийн орлогын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан үзэхэд:

2023 онд Алтай, Алтанцөгц, Баяннуур,Бугат, Дэлүүн, Сагсай, Өлгий сумуудын торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсан ба Бугат, Сагсай сумууд 2024 оны торгуулийн орлогыг төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж, бусад сумууд нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт№5 Сумуудын 2023,2024 оны торгуулийн орлогын гүйцэтгэл сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	2023 он		Зөрүү	2024 он		Зөрүү
		Төл	Гүй		Төл	Гүй	
1	Алтай	7.3	5.1	- 2.2	7.3	10.0	2.7
2	Алтанцөгц	7.3	6.6	- 0.6	7.3	9.0	1.7
3	Баяннуур	14.1	11.3	- 2.7	27.3	11.9	- 15.4
4	Бугат	24.3	19.8	- 4.5	7.3	9.7	2.4
5	Булган	7.3	8.2	0.9	7.3	15.3	8.0
6	Буянт	7.3	9.1	1.9	7.3	20.1	12.8
7	Дэлүүн	7.3	6.1	- 1.1	7.3	12.4	5.2
8	Ногооннуур	7.5	9.3	1.7	7.3	10.7	3.5
9	Сагсай	7.3	6.5	- 0.7	5.7	13.1	7.4
10	Толбо	7.3	11.2	3.9	14.8	14.7	- 0.1
11	Улаанхус	20.3	20.6	0.3	37.3	16.6	- 20.6
12	Цэнгэл	12.3	27.5	15.2	43.3	55.6	12.4
13	Цагааннуур	18.0	26.2	8.2	25.0	21.6	- 3.4

14	Өлгий	800.0	250.9	- 549.1	839.3	239.1	- 600.2
15	Аймаг	213.0	555.9	342.9	1,187.4	715.8	- 471.6
	Дүн	1,160.1	974.2	- 185.9	2,230.6	1,175.5	- 1,055.1

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2023, 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

А.2.3. Хүүгийн орлого төлөвлөөгүй байна

Тус аймгийн орон нутгийн төсөвт 2023, 2024 онуудад хүүгийн орлого төлөвлөгөөгүй байна.

А.2.4. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолж, төлөвлөж ирсэн байна.

Торгуулийн орлогоор төлөвлөсөн орлогын 40-ээс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд төлөвлөж ажиллаж байна.

Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар баталсан зардлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зардалд тусгаж баталж өгсөн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг аймгийн ИТХ-ын дарга ахалж ажилладаг ба жилийн эхэнд зөвлөлийн хурлаар зардлын зарцуулалтыг төлөвлөж ажилладаг байна.

Мөн торгуулийн орлогоос аймгийн Замын санд жил бүр хөрөнгө хуваарилахаар төсөвт тусгаж баталсан байна.

А.2.5. Торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлт өгч ажилласан байна

Торгуулийн орлогын төлөвлөгөөний биелэлт хүлээгдэж буй гүйцэтгэлээр хангалтгүй байгаа нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлт хийж 2023 онд аймгийн Засаг даргын захирамжаар татварын өр барагдуулах аяныг зохион байгуулж байсан байна. Аймгийн Засаг дарга эрх бүхий байгууллагуудтай орлого төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэл өгч ажиллаж ирсэн байна.

А.2.6. Орлогын эх үүсвэрийг үндэслэлгүй тооцоолсон гэж үзэх үндэстэй байна.

Торгуулийн орлогын эх үүсвэрийг тооцоолохдоо Татварын газрын бааз, Цагдаа, Шүүхийн байгууллагын холбогдох тооцоо судалгаа, эрх бүхи байгууллагуудаас авсан тоо мэдээ, судалгаанд үндэслэж тооцоолж байна. Торгуулийн орлогын төлөвлөгөө 2023, 2024 онуудад биелэгдээгүй байгааг орлогыг хэт өндөр тооцож үндэслэлгүй тооцоолсонтой холбоотой байна.

Торгуулийн орлогыг жилээр, улирлаар төлөвлөж, биелэлтийг хангаж ирсэн нь иргэдэд өрийн дарамт учруулж, төсөв бүрдүүлэх зорилгоор иргэдийг өрийн дарамтад оруулах эрсдэл үүсгэж байна гэж үзэх үндэстэй.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдсанаас хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон боловч “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам нь” батлагдсан хугацаанаас хойш шинэчлэгдээгүй байна.

А.3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА

А.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэхтэй холбоотой хуулийн зарим заалтууд уялдаагүй байна

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлд “Иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг” гэсэн заалтад иргэний өөрийн бичиг баримтаа хадгалах, эзэмших, бусдад барьцаалахгүй байх, зориуд гэмтээхгүй байх гэсэн үүргийг заасан байна.Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24.4 дэхь заалтаар зөрчил гаргасан иргэдийг торгохоор заасан боловч хуульд заасан заалтууд Иргэний үнэмлэхийн дүрэмд ороогүй байна.

Орон нутгийн зарим төсөвт байгууллагуудын торгуулийн орлого нь улсын төсөвт төвлөрч байгаагийн эрх зүйн үндэс нь тодорхойгүй байна.Тухайлбал:

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар, Нийгмийн даатгалын газар, Статистикийн хэлтэс, Автотээврийн төв, Соёл, урлаг, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газруудын 2023 онд 58.4 сая төгрөгийн, 2024 онд 51.1 сая төгрөгийн торгуулийн орлого нь улсын төсөвт төвлөрсөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т “улсын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23 дугаар зүйлийн 23.5.3-т “хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого” гэсэнд орон нутгаас орох торгуулийн орлого орох эсэх нь тодорхойгүй байна.

А.3.3. Орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх хуулийн тодорхойгүй маргаантай заалтууд байна

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-д Засгийн газрын 2025 оны 126 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан байна.

Зөрчлийн тухай хуулийн 15.26 дугаар зүйлийн 2-т “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам,тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам зөрчсөн хуулийн этгээдийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтад архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8. дугаар зүйлийн 6.20 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 10.20-д “Тамга, тэмдэг үйлдвэрлэх хэрэглэх, хадгалах журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтад улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн буюу нэг төрлийн зөрчлийг 2 байгууллагын шийдвэрлэх зөрчилд харьяалуулсан байна.

Харьяалалгүй хүний хувьд хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүй тул гадаадын иргэний нэгэн адил Зөрчлийн тухай хуулиар шалган шийдвэрлэж байгааг тодорхой болгох шаардлагатай байна.

А.3.4.Үйлсэн зөрчилд харилцан адилгүй торгууль оногдуулжээ

Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д заасан зөрчилд хүнийг 20 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан нь маш бага,

Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1-д заасан зөрчилд ногдуулж буй торгуулийн хэмжээ бага,

Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд заасан зөрчил, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д заасан зөрчилд давхар торгууль оногдуулж байгаа,

Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1 дэхь заалтад заасан зөрчилд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэхь заалтад “нас барьсныг аймаг, нийслэлд 3 хоног, сум, дипломат төлөөлөгчийн газарт 7 хоногт бүртгүүлнэ” гэсэн заалт ордог.Нас барьсан хүнийг улсын бүртгүүлд бүртгүүлэх хугацаа богино байгаа, хүндэтгэх шалтгаантай байгаа нь амьдралд хэрэгжих боломжгүй бэрхшээл үүсгэж байна.

А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна

Аймгийн татварын бус орлогын 40.0-60.0 хувийг 2023-2024 онуудад торгуулийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж ирсэн байна.

Торгуулийн орлогыг жилээр, улирлаар төлөвлөж, биелэлтийг хангаж ирсэн нь иргэдэд өрийн дарамт учруулж, төсөв бүрдүүлэх зорилгоор иргэдийг өрийн дарамтад оруулах эрсдэл үүсгэж байна гэж үзэх үндэстэй.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдсанаас хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон боловч “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам нь” батлагдсан хугацаанаас хойш шинэчлэгдээгүй байна.

Сумын Төрийн сангууд орон нутагт тухайлсан жилд тавигдсан торгуулийн орлогын хэмжээ, түүний барагдуулалтын талаар мэдээлэл солилцдоггүй, оногдуулсан торгууль, түүний барагдуулалтын талаар мэдээлэлгүй байдаг байна.

Аймгийн нийт эрх бүхий 18 байгууллагаас 2023 онд тавьсан торгуулийн 86.4 хувийг барагдуулж, 167.7 сая төгрөгийн барагдаагүй үлдэгдэлтэй, 2024 онд тавьсан торгуулийн 76.4 хувийг барагдуулж, 354.6 сая төгрөгийн барагдаагүй үлдэгдэлтэй гарчээ.

2024-2024 онд тавьсан торгуулийн 76.3-78.0 хувийг Цагдаагийн газраас тавьсан торгууль эзэлж, тавьсан торгуулийн орлогын барагдалтын дүн 76.8-84.3 хувийг эзэлжээ.

Их хэмжээний торгууль тавьдаг төсөвт байгууллагуудын зөрчлийг зөрчлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж ажиллаж байгаа боловч төрийн байгууллагуудын мэдээлэл солилцдоггүй, хангалтгүй зэргээс торгуулийн үлдэгдлийг насжилтаар нь ангилах боломжгүй байна.

БҮЛЭГ 2. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Б.1. Ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна

Б.1.1. Ногдуулсан торгуулийн орлогоос 2024 оны эцсийн байдлаар 3 байгууллага 468.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна

Аймгийн хэмжээнд 2023 онд 1,158.5 сая төгрөгийн, 2024 онд 1,232.4 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрсөн байна.

Хүснэгт №6 Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлт

сая төгрөгөөр

Он	Торгуулийн орлого		
	Ногдуулсан	Төвлөрүүлсэн	Зөрүү
2023 он	1362.2	1158.5	-203.7
2024 он	1588.3	1233.1	-355.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн дүнгээр 2023 онд 18 байгууллагаас 31061 зөрчилд 1,362.2 сая төгрөгийн торгууль ногдуулснаас гүйцэтгэлээр 1,158.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба төвлөрүүлээгүй торгуулийн үлдэгдэл 203.7 сая төгрөг байна. Хууль хяналтын байгууллагад 17.4 сая төгрөгийг төлүүлэхээр шилжүүлсэн ба үүнээс 10.0 сая төгрөгийг Шүүхээс хэрэгсэхгүй болгосон байна.

Дээрх үзүүлэлт 2024 оны байдлаар судалж үзэхэд: 2024 онд 18 байгууллага 20452 зөрчилд 1,588.3 сая төгрөгийн торгууль ногдуулж, гүйцэтгэлээр 1,233.1 сая төгрөгийг төвлөрүүлж 355.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тухайн онд 195.0 сая төгрөгийг төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад шилжүүлснээс 30.0 сая төгрөгийг хууль хяналтын байгууллага хэрэгсэхгүй болгосон байна.

Торгуулийн орлогын үлдэгдэл, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байдал

сая төгрөгөөр

Он	Зөрчлийн тоо	Торгууль			Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	Хууль хяналтын байгууллагаас хэрэгсэхгүй болгосон
		Ногдуулсан	Төлсөн	Үлдэгдэл		
2023 он	31061	1362.2	1158.5	203.7	17.4	10.0
2024 он	20452	1588.3	1233.2	355.1	195.0	30.0
Дүн	51513	2950.5	2391.7	558.8	212.4	40.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн эрх бүхий байгууллагуудын өмнөх онуудад ногдуулсан торгуулын орлогоос 2023 оны эхэнд нийт 58.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд: Аймгийн Татварын газар 36.6 сая төгрөгийн, Гаалийн газар 19.6 сая төгрөгийн, Гадаадын иргэн харьяатын газар 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт№8

Торгуулийн орлогын үлдэгдэлийн судалгаа

Сая төгрөгөөр

Эхний үлдэгдэл /2023.01.01/	2023 оны ногдуулалт	2023 оны төлөлт	Үлдэгдэл /2023.12.31/	2024 оны ногдуулалт	2024 оны төлөлт	Үлдэгдэл /2024.12.31/
58.1	1362.7	1158.3	262.5	1,588.3	1,233.2	617.6

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитаар хийсэн судалгаагаар 2024 оны эцсийн байдлаар тус аймгийн эрх бүхий байгууллагуудын ногдуулсан торгуулийн орлогоос төвлөрөөгүй орлогын үлдэгдэл 12 байгууллагад 617.6 сая төгрөг байна.

Хүснэгт№9

Торгуулийн орлогын үлдэгдэлтэй байгууллагуудын судалгаа

Сая төгрөгөөр

№	Байгууллагын нэр	Үлдэгдэл /2024.12.31/
1	Байгаль орчны газар	36.7
2	Татварын газар	66.2
3	Гаалийн газар	19.6
4	Гадаадын иргэн харьяатын газрын аймаг дахь хэлтэс	2.0
5	Нийгмийн даатгалын газар	0.3
6	Статиктийн хэлтэс	0.1
7	Аймгийн ЗДТГ	60.5
8	Цагдаагийн газар	416.5
9	Мал эмнэлгийн газар	4.5
10	Автотээврийн төв	0.3
11	Хүнс хөдөө аж ахуйн газар	1.0
12	ГХБХБГазар	10.0
	Дүн	617.6

Эх сурвалж: Аудитын судалгаа

Гаалийн газар, Гадаадын иргэн харьяатын газрын аймаг дахь хэлтэс, аймгийн ЗДТГ, ГХБХБГ зэрэг байгууллагууд нийт 92.1 сая төгрөгийг төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Аймгийн Цагдаагийн газрын хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 60.0 сая төгрөгийг хасаж тооцоход 356.5 сая төгрөг, Байгаль орчны газар 36.7 сая төгрөг, Татварын газар 66.2 сая төгрөг, нийт 468.4 сая төгрөгийг төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Дээрх байдал нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна”, 8 дах хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Эрх бүхий албан тушаалтнаас

оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.4, 2.4.2 дахь заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Иймд дээрх байгууллагуудад хууль, тотоомжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар зөвлөмж өгөв.

Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан байна

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг Зөрчлийн тухай хуультай уялдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор батлагдсан ба хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь заалтад эрх бүхий албан тушаалтан бүрээр шалган шийдвэрлэх зөрчлийг тодорхой заасан.

Аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх 23 байгууллагын 267 эрх бүхий албан тушаалтан байна. Дээрх эрх бүхий байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд торгуулийг тавьсан байна.

Б.1.3. Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгаж тайлагнасан байна

Сумуудын торгуулийн орлогын гүйцэтгэлийг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд, сумууд болон аймгийн дүнг нэгтгэсэн байдлаар торгуулийн орлогын гүйцэтгэлийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж тайлагнаж байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар орлого бүрдүүлэлтэд аудит хийж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан эсэхийг баталгаажуулж байна.

Аймгийн ТЕЗ, сумуудын ТТЗ-дын нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг үнэн зөв тусгаж, тайлагнасан байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт голлох нөлөөг үзүүлж байна

Аймгийн 2023 оны орон нутгийн орлогын гүйцэтгэл 20,911.2 сая төгрөг ба үүний 5 хувийг торгуулийн орлого эзэлж байна. Татварын бус орлогын гүйцэтгэлийн 41 хувийг торгуулийн орлогоос бүрдүүлсэн байна.

Дээрх үзүүлэлтийг 2024 оны байдлаар авч үзэхэд: Орон нутгийн төсвийн орлогын 3 хувийг торгуулийн орлого эзэлж байгаа бол татварын бус орлогын 42 хувийг торгуулийн орлогоос бүрдүүлсэн байна.

Хүснэгт №10 Торгуулийн орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь сая төгрөгөөр

Он	Орон нутгийн нийт орлого	Татварын бус орлого	Торгуулийн орлого	Торгуулийн орлогын	
				Нийт орлогод эзлэх хувь	Татварын бус орлогод эзлэх хувь
2023 он	20,911.2	2,362.4	974.2	5%	41%
2024 он	36,463.2	2,821.9	1175.5	3%	42%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Торгуулийн орлогын гүйцэтгэлийг үндэслэж дүгнэлт хийхэд торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн 3-аас 5 хувийг бүрдүүлж ирсэн байна. Татварын бус орлогын 42 хувийг бүрдүүлж байгаа нь багагүй үзүүлэлт ба орон нутгийн орлогын эх үүсвэрт үзүүлэх нөлөөлөл нь өндөр байна.

Б.2. Зарим сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зардал хуваарилаагүй байна.

Б.2.1. Төсөв хуваарилах эрх бүхий зарим байгууллага бүрэн эрхээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 132 дугаар тогтоолоор 2023 оны төсөв батлахдаа хүү, торгуулийн орлогыг 213.0 төгрөг, сумдын ИТХ-аар 2024 оны төсвөө батлахдаа хүү, торгуулийн орлогыг нийт 947.1 сая төгрөг байхаар баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 221 дүгээр тогтоолоор 2024 оны төсөв батлахдаа хүү, торгуулийн орлогыг 1,187.4 сая төгрөг, сумдын ИТХ-аар 2024 оны төсвөө батлахдаа хүү, торгуулийн орлогыг нийт 1,043.3 мянган төгрөг байхаар баталсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн ИТХ-ын тогтоолоор 2023 онд 198.0 сая төгрөг, 2024 онд 185.3 сая төгрөгийг хуваарилж баталсан ба Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумууд 2023 онд нийт 38.0 сая төгрөг, 2024 онд 48.0 сая төгрөгийг хуваарилан баталсан байна. Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн сумууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төсөв хуваарилж батлаагүй, хуулиар заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт№11 Аймаг болон сумдын 2023-2024 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн төлөвлөгөө

сая төгрөгөөр

№	Сумын нэр	Батлагдсан зардал	
		2023	2024
1	Ногооннуур	15.9	12
2	Сагсай	-	4.5
3	Толбо	3.4	5.5
4	Улаанхус	3	1
5	Цэнгэл	6	8
6	Өлгий	10	17
7	Аймгийн ИТХ	198	137.3
Нийт дүн		236.3	185.3

Эх сурвалж: Аймаг сумдын ИТХ-ын тогтоол, санхүүгийн тайлан

Авто замын санд төвлөрүүлэх хөрөнгө оруулалтыг 2023 онд 1,153.7 сая төгрөг, 2024 онд 1,863.9 сая төгрөгөөр тус тус хуваарилан баталжээ.

Б.2.2. Зарим сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зардал хуваарилж батлаагүй байна

Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгуулийн орлого нь улсын болон орон нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд тухайн байгууллагад шууд зарцуулдаггүй байна. Харин хууль, журмаар тусгайлан зохицуулсан тодорхой чиглэлд зарцуулах боломжтой байна. Тухайлбал:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ” гэж заажээ.
- Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-т Аймаг, нийслэлийн санхүүгийн байгууллага дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа энэ журмын 2-д заасан улсын орлогод оруулсан орлого болон төсөвт тушаасан мөнгөний тухайн жилийн урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн түүний 40 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг тооцож төсвийн зарлагад тусгай зүйл болгон тусгаж төлөвлөнө”, 4-т “Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилийн төсвийг батлахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл /цаашид Зөвлөл гэнэ/ -ийн нэрээр тусад нь нэр зааж батлахаас гадна тухайн сум, дүүргийн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан гаргасан хуваарийг үндэслэн сум, дүүрэг тус бүрээр нэр зааж батална. Уг хөрөнгийг сум, дүүргийн батлагдсан төсөв дээр нэмж олгоно” гэж заажээ.

Дээрх хуулийн заалтын дагуу аймаг, сумдын ИТХ-аас 2023-2024 онуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг баталсан байна.

Батлагдсан санхүүжилтийг өмнөх онуудын төвлөрүүлсэн торгуулийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулсан үзүүлэлтийг харуулахад:

Хүснэгт №12 Өмнөх онд төвлөрсөн торгуулийн орлого болон 2023-2024 онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн төлөвлөгөө

сая төгрөгөөр

№	Сумын нэр	2022 оны орлогын гүйцэтгэл	2023 оны төлөвлөгөө		2023 оны орлогын гүйцэтгэл	2024 оны төлөвлөгөө	
			Дүн	Хувь		Дүн	Хувь
1	Алтай	9.5	-	-	5.1	-	-
2	Алтанцөгц	13.3	-	-	6.6	-	-
3	Баяннуур	46.1	-	-	11.3	-	-
4	Бугат	7.4	-	-	19.8	-	-
5	Булган	11.6	-	-	8.2	-	-
6	Буянт	12.5	-	-	9.1	-	-
7	Дэлүүн	4.7	-	-	6.1	-	-
8	Ногооннуур	28.3	15.9	56.2	9.3	12	129.7

9	Сагсай	10.1	-	-	6.5	4.5	69
10	Толбо	14.9	3.4	22.8	11.2	5.5	49.3
11	Улаанхус	14.3	3	21	20.6	1	4.9
12	Цэнгэл	17.7	6	33.9	27.5	8	29.1
13	Цагааннуур	18.4	-	-	26.2	-	-
14	Өлгий	288	10	3.5	250.9	17	6.8
15	Аймаг	351.4	198	56.3	555.9	137.3	24.7
	Дүн	848.2	236.3	27.9	974.2	185.3	19.0

Эх сурвалж: Аймаг сумдын ИТХ-ын тогтоол, санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах зардлыг 2023 онд 236.3 сая төгрөгөөр буюу 2022 онд төвлөрсөн торгуулийн орлогын 27.9 хувиар төлөвлөж, 12.1 хувиар дутуу, 2024 онд 185.3 сая төгрөгөөр буюу 2023 онд төвлөрсөн торгуулийн орлогын 27.9 хувиар төлөвлөж, 21.0 хувиар дутуу баталсан нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1дэх заалттай нийцэхгүй байна.

Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн сумууд 2023-2024 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төсөв батлаагүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын батлагдсан төлөвлөгөөний өмнөх оны төвлөрүүлсэн орлого дахь эзлэх хувь нь Өлгий суманд хамгийн бага буюу 3.5 хувьтай байхад Ногооннуур суманд хамгийн өндөр буюу 129.7 хувьтай байна. Энэ нь төлөвлөлт бодитой бус байгааг харуулж байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст сумуудад торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зөрчлийг арилгах талаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгөв.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ” , 25.2.4- т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-д заасны дагуу авто замын санд төвлөрүүлэх хөрөнгө оруулалтыг 2023 онд 1,153.7 сая төгрөг, 2024 онд 1,863.9 сая төгрөгөөр тус тус хуваарилан баталжээ.

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

Байгууллагууд хүү, торгуулийн орлого төвлөрүүлэлтийн дүнгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

Торгуулийн орлогын төлөвлөгөө биелүүлж, төвлөрүүлсэн орлогын хэмжээнээс хамаарч торгууль ногдуулсан эрх бүхий албан тушаалтанд цалингийн урамшуулал олгох хууль эрх зүйн зохицуулалт, журам батлагдаагүй байна.

БҮЛЭГ 3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ХУВААРИЛСАН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ ЗОХИХ ҮР ДҮНГ ӨГСӨН БАЙНА**В.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна****В.1.1. Хүү, торгуулийн орлогыг хуульд заасны дагуу хуваарилж зарцуулсан байна**

Аймгийн хэмжээнд 2023 онд орон нутгийн хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна. 2024 онд Ногооннуур суманд 0.5 сая төгрөгийн хүүгийн орлого төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт оруулж зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн хүүгийн орлого нь 2023 онд 52.1 сая төгрөг, 2024 онд 63.3 сая төгрөг орсон ба тус орлогыг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу зарцуулсан байна.

Байгууллагын хувьд Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгуулийн орлого нь улсын болон орон нутгийн төсөвт төвлөрдөг ба тухайн байгууллага нь зарцуулах эрхгүй байна.

Харин хууль, журмаар тусгайлан зохицуулсан тодорхой чиглэлд хуваарилагдан батлагдаж байгаа зардлын хувьд:

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №13 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, зарцуулалт

/сая төгрөг/

№	Сумын нэр	2023		2024	
		Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл	Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл
1	Ногооннуур	15.9	4.9	12.0	5.0
2	Сагсай	-	-	4.5	3.1
3	Толбо	3.4	3.4	5.5	5.5
4	Улаанхус	3.0	2.4	1.0	1.0
5	Цэнгэл	6.0	0.4	8.0	1.4
6	Өлгий	10.0	10.0	17	16.6
7	Аймгийн ИТХ	198.0	198.0	137.3	137.2
Нийт дүн		236.3	219.1	185.3	169.8

Эх сурвалж: аймаг, сумдын ИТХ-ын санхүүгийн тайлан, төсвийн хэлбэлзэл

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд нийт 421.6 сая төгрөг төлөвлөн баталж гүйцэтгэлээр 388.9 сая төгрөгийг зарцуулж, 32.7 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2023-2024 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд баталсан төсвийг дараах зардалд зарцуулсан байна: Үүнд:

- Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 41.2 сая төгрөгийг,
- Зам, тээврийн осол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 38.5 сая төгрөгийг,
- Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 12.9 сая төгрөгийг,
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 43.4 сая төгрөгийг,
- Бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 129.9 сая төгрөгийг,
- Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд болох аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газруудад нэн шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардалд 69.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн ихэнх хувийг хууль сурталчлах, сургалт зохион байгуулах гарын авлага танилцуулга бэлтгэх, тоног төхөөрөмж, томилолт шатахууны зардалд зарцуулагдсан байна.

Аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 2023-2024 онд 12 байгууллагад нийт 253.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Нийт олгосон санхүүжилтийн 45.8 хувь буюу 116.1 сая төгрөгийг Цагдаагийн газарт, 21.1 хувь буюу 53.6 сая төгрөгийг Прокурорын газарт, 6.4 хувь буюу 16.1 сая төгрөгийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт, 5.9 хувь буюу 15.0 сая төгрөгийг Хилийн цэргийн 0165 дугаар ангид, 5.7 хувь буюу 14.5 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт, 5.2 хувь буюу 13.2 сая төгрөгийг Онцгой байдлын газарт шилжүүлсэн байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын батлагдсан төсвийн зарцуулалтад жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн шалгадаг бөгөөд 2023-2024 онд алдаа зөрчил илрээгүй байна.

В.1.2. Торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулаагүй байна

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу аймгийн ИТХ-ын бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд баталж, зарцуулсан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлд горим сорил хэрэгжүүлж түүвэрлэн шалгахад аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн, зарцуулаагүй байна.

В.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байна

Аймгийн ИТХ-ын тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд нийт 335.3 сая төгрөгийн 59 арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Прокурорын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хилийн цэргийн 0165 болон 0285 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, Боловсролын газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, аймаг сумдын Засаг дарга, ИТХ зэрэг байгууллага, албан тушаалтнууд хэрэгжүүлж байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, зорилтот бүлгийг хамгаалах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.

Тайлант онуудад хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдэд хүүхэд, өсвөр үе, залуучууд, эцэг эх, ахмад настан, төрийн албан хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх хүн амын бүх бүлгийг хамруулан 13 сумд болон багийн иргэдэд хүрч ажиллахыг зорилго болгон зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх “Хамтарсан баг”-уудыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, сумдын иргэд, төрийн албан хаагч нарт сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж үүнд 13 сумын 2600 иргэнийг;
- “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяныг аймгийн хэмжээний бүх ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж, 5000 гаруй сурагч, 600 гаруй багш, эцэг эхийг;
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр 6 аян, арга хэмжээг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 1080, хувиараа хөдөлмөр эрхлэгч 850, малчин 1200, оюутан 300, сурагч 6100, ажилгүй иргэн 780 нийт 10310 иргэнд 98 удаагийн сургалт, 26 удаагийн уулзалт хэлэлцүүлэг, 3 өдөрлөг, 3 уралдаан тэмцээнийг зохион байгуулсан байна.
- Зорилтот гэр бүлийн гишүүдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг арга олгох 19 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 3584 иргэнийг хамруулсан байна;
- “Архигүй-Аз жаргалтай гэр бүл” нийтлэлийн уралдаан, “Архины хор уршиг” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулж, видео хичээл бэлтгэн байгууллагын вэб сайт болон пэйж хуудсаар дамжуулан нийт 8542 хүнд түгээсэн байна.
- Мэдээ, мэдээллийг Орон нутгийн “Дербес” телевиз, радио, олон нийтийн сүлжээ, LED дэлгэц, хэвлэмэл тараах материал, сурталчилгааны самбар зэрэг олон талт сувгаар зохион байгуулж иргэдэд хүргэсэн байна.
- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран “Урам хайрлая” өдөрлөгийг зохион байгуулж, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 80 гаруй иргэнийг нийгэмшүүлэх, ажлын байраар

хангах, холбогдлох газруудад зуучлах зорилгоор сургалт, мэдээлэл хүргэж, спортын тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулсан байна.

В.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний үр дүнд тайлант онуудад зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн түвшин буурсан байна. Тухайлбал:

2023 онд:

- Тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч зугтаах гэмт хэрэг 2 нэгжээр буюу 33.3 хувиар,
- Мал хулгайлах гэмт хэрэг 10 нэгжээр буюу 52.6 хувиар,
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 10 хувиар,
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийг ашиглалтын эсрэг гэмт хэрэг 15 нэгжээр буюу 62.5 хувиар тус тус буурсан ба өмнөх онуудад бүртгэгдэж байсан халаасны хулгай, галт зэвсэг хулгайлах, дээрэмдэх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

2024 онд:

- Дээрэмдэх гэмт хэрэг 2 нэгж буюу 66.6 хувиар,
- Хөрөнгө завших гэмт хэрэг 19 нэгж буюу 82.6 хувиар,
- Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 нэгж буюу 25 хувиар тус тус буурсан байна.

Зам, замын байгууламжийн хяналт хэрэгжүүлж, аймгийн төвд 3 цэгт явган хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, аялал жуулчлалын бүс нутгийн замд 10 цэгт мэдээллийн самбар, аймгийн төвөөс орох гарах 4 чиглэлд 360 градус эргэдэг хяналтын камер шинээр суурилуулах ажлыг шийдвэрлүүлснээр хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг буурсан байна.

Мөн Хилийн цэргийн 0165, 0285 дугаар ангиудтай хамтарч хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлт сахиулах, аялал зугаалгаар явагсдын хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор Даян болон Цагааннуурын хилийн боомтын чиглэлд, мөн түүнчлэн аялал жуулчлалын бүс болох Хотон, хурган нуурын чиглэлд орчин үеийн үзүүлэлт бүхий 360 градус эргэдэг хяналтын камерыг суурилуулснаар хилийн хяналтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Мөн аялал жуулчлалын бүс нутагт хяналтын камер суурилуулснаар аялагчдад тавих хяналт сайжирч, болзошгүй аюул ослоос /ой хээрийн түймэр....г.мэт/ урьдчилан сэргийлэх, байгаль орчинд ээлтэй арга хэмжээ болсон байна.

“Ногоон бүс” төслийн хүрээнд Өлгий сумын төвд гудамж талбайд 14 байршилд 20 хяналтын камер суурилуулснаар иргэдийн аюулгүй амьдрах, гэмт хэрэг зөрчил буурч эерэг нөлөө үзүүлж байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг байгууллагууд болон архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, борлуулдаг дэлгүүр, үйлчилгээний газруудын теле хяналтын камертай эсэхэд хяналт хийж, гарсан зөрчлийг арилгах шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулснаар гэмт хэргийн илрүүлэлтэд эергээр нөлөөлсөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг, тэмцээн уралдаан зохион байгуулснаар олон нийтийн цагдаа, төрийн албан хаагчдын чадавх сайжирч, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, хариуцлага, нийгмийн ухамсар дээшилж нийгмийн харилцаанд эерэг соёл төлөвшүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхийг дэмжих нөхцөлийг бүрдүүлж байна.

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна

В.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байна

Цахим мэдээллийн Shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг бүртгэх тусгай цэс байхгүй байна.

Аймаг сумдын ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 219.1 сая төгрөг, 2024 онд 169.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулалттай холбоотой шийдвэр болон 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий 148.3 сая төгрөгийн 18 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлсэн байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна”, 5.1.1 дэх заалтад “Шилэн дансны бие даасан цэстэй байх”, 5.7 дахь хэсэгт “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасны дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг мэдээллийн самбарт байршуулсан байна.

Аймгийн ИТХ нь мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор ухаалаг самбар байршуулсан ба иргэд тухайн ухаалаг самбарт хандаж байгууллагын үйл ажиллагаа, бусад мэдээ мэдээллийг нээлттэй авах боломж бүрдсэн байна.

В.2.2. Торгуулийн орлогын зарцуулалтын тайланг олон нийтэд мэдээлж иржээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн жилийн эцсийн тайланг Хууль зүй дотоод хэргийн яамны дэргэдэх Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд жилд 2 удаа тайлагнадаг байна.

Тайланд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн, хийсэн ажлын үр дүнг тусгаж иржээ.

Салбар зөвлөлийн ажлын тайланг аймгийн ИТХ-ын хуралдаанд тайлагнаж, орон нутгийн “Дербес” телевизээр ярилцлага хийж, “Баян-Өлгий гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл” фейсбүүк пейж дээр богино хэмжээний видео хэлбэрээр мэдээлэл хүргэж ажиллаж байна.

В.2.3 Торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд оролцогч талуудаас үнэлгээ өгөөгүй байна

Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой хяналт тавьж, ил тод байдалд үнэлгээ өгөөгүй, санал гараагүй байна.

БҮЛЭГ 4. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭЭГҮЙ

Г.1.1 Байгууллагуудын хооронд мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна

Өнөөгийн байдлаар байгууллага бүр торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтаны ногдуулсан торгуулийн мэдээлэл бүхий өөр өөрсдийн бүртгэлийн программ хангамжийг ашигладаг, зарим эрх бүхий байгууллагууд бүртгэлийн цахим систем ашиглахгүй байгаа нь мэдээллийн нэгдсэн сан, тогтолцоо бүрдээгүйг илтгэж байна.

Улсын прокурорын ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар тушаал-ын дагуу “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан”-г 2022 оноос туршилтаар ашиглаж эхэлсэн боловч энэхүү систем нь одоогоор орон даяар бүрэн хэрэгжээгүй байна.

Зөрчил бүртгэл,мэдээллийн санд Цагдаагийн газар болон Гадаадын иргэн, харъяатын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс зөрчлийн мэдээлэлээ бүртгэж хэвшсэн байна.

Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын хувьд дотооддоо ашигладаг мэдээллийн системтэй ба салбарын хуулиудад мэдээллийн систем ашиглах чиглэлийг баримтлах талаар дараах байдлаар тусгажээ.Үүнд:

- ✓ Татварын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.1⁶ дэх хэсэгт мэдээллийн сан ашиглахаар,
- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2⁷ дахь хэсэгт улсын бүртгэлийн мэдээллийн санг ашиглахаар ,
- ✓ Гаалийн тухай хуулийн 13 дугар зүйлийн 13.3⁸ дахь хэсэгт гаалийн үйл ажиллагааны мэдээллийн санг ашиглахаар,
- ✓ Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1⁹ дэх хэсэгт мэдээллийн санг ашиглахаар,
- ✓ Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 24.1-д заасан цогцолбор арга хэмжээг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /цаашид “цахим систем” гэх/-ийг ашиглахаар,
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1¹⁰-т мэдээллийн санг ашиглахаар, мэдээллийн санд байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллээс бүрдэнэ гэж тусгасан байна.

Дээрх хуулийн зохицуулалттай холбоотой зарим байгууллагууд дараах мэдээлэлийн сангуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.Үүнд:

- Татварын газар Таис системээр орлогыг бүртгэж, ТЕГ-ын Татвар хураалтын удирдлагын газар нэгдсэн сан үүсгэдэг.

- Гаалийн газар Caïs системээр орлогыг бүртгэж, ГЕГ-ын газрын орлогын газарт нэгдсэн сан үүсгэдэг.
- Нийгмийн даатгалын газар SIGOS системд орлогыг бүртгэж, НДЕГ-ын хэмжээнд нэгдсэн сан үүсгэдэг.
- Цагдаагийн газар торгуулийн орлого бүртгэдэг нэгдсэн сангүй боловч Зөрчлийн хэрэг бүртгэлийн нэгдсэн сангаас бэлэн бус торгуулийн төлбөрийг барагдуулсан эсэх хянах боломжтой тийм/үгүй гэсэн сонголттой мэдээлэл татагддаг бол бэлэн торгуулийг гараар бүртгэл хийж явдаг байна.

Гэвч дээрх байгууллагуудын мэдээллийн системүүд хоорондоо уялдаа холбоогүй, өгөгдлийн нэгдсэн сан үүсгээгүй, харилцан мэдээлэл солилцох боломжгүй байгаа нь торгуулийн шийдвэрлэлт, хяналт-шинжилгээ, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

Аймаг, сумдын төрийн сангийн хувьд торгууль ногдуулах байгууллагуудтай мэдээлэл солилцох мэдээлэлийн сангүй учраас аль байгууллагаас ямар хэмжээний торгууль, хэзээ ногдуулсан зэрэг мэдээллийг бүрэн авч чадахгүй байгаа нь торгуулийн орлогын төлөвлөлтийг үнэн зөв, бодитой хийхгүй байх, орлогын бүрдэлтэд үр дүнтэй хяналт хэрэгжүүлэхгүй байх, төсвийн орлого тасрах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.

Иймд улсын хэмжээнд торгуулийн мэдээллийн бүртгэлийг нэгтгэх, эрх бүхий байгууллагуудын ногдуулсан торгуулийн шийдвэр, биелэлтийн явцыг нэгдсэн байдлаар хянах боломжтой бүртгэлийн системийг нэвтрүүлж, цахим мэдээллийн сантай болох зайлшгүй шаардлагатай байна

Г.1.2. Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна

Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт Цагдаагийн газрын хувьд зохих түвшинд хангагдаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд торгох шийтгэлд заасан торгуулийг бэлэн, эсхүл бэлэн бус хэлбэрээр төлнө” гэж заасан.

Зөрчилд холбогдогч нь торгуулийг арилжааны банкаар , *E-Mongolia, Smartcar, Ebarimt, Gerege, Datacenter* куоск болон бусад аппликейшнээр дамжуулан бэлэн ба бэлэн бус хэлбэрээр төлж байна. Тухайлбал: Цагдаагийн газрын бэлэн бус торгууль нь дараах хэлбэрээр төлөгдсөн байна. Үүнд:

Цагдаагийн газрын бэлэн бус торгууль төлсөн хэлбэр

(сая төгрөгөөр)

Торгууль төлсөн хэлбэр	2023 он		2024 он		Нийт мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
E-Mongolia	9476	196	5941	147.4	343.4
Ebarimt	65	1.3	3	0.06	1.36
Gerege	2779	68.3	1653	50.9	119.2
Smartcar	3627	75.8	1381	35.3	111.1
Банк	5031	122.7	3090	90.4	213.1
Бусад аппликейшн	146	3.5	77	3.1	6.6
Нийт дүн	21124	467.6	12145	327.16	794.76

Хүснэгтээс харахад нийт 794,76 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлснээс 213,1 сая төгрөг буюу 26.8 хувийг банкаар, 581,6 сая төгрөг буюу 73.2 хувийг *E- Mongolia, Ebarimt, Gerege, Smartcar, болон бусад* аппликейшнээр төлсөн байна.

Энэ нь ногдуулсан торгуулийг олон төрлийн төлбөрийн хэрэгсэлийг ашиглан хялбар, хурдан шуурхай төлөх боломжтой болсныг харуулж байна.

Бусад эрх бүхий байгууллагуудын хувьд төрийн сангийн дансны хуулга авч тулган баталгаажуулалт хийсний дараа торгууль төлөгдсөн эсэх талаар мэдээлэлтэй байгаа нь торгууль барагдуулах, хянах, мэдээлэхэд хүндрэл учруулж байна.

Г.1.3. Нэгдсэн хяналтын систем бүрдээгүй байгаа нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна

Аудитын дүнгээс харахад торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, бие даасан хяналтын систем үйл ажиллагаа байхгүй, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д заасанаар торгууль оногдуулсан эрх бүхий албан тушаалтан нь тухай торгуулийг барагдуулдаг нь орлогын бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хяналтын системээр эрх бүхий албан тушаалтны зөрчлийн ажиллагааг бүрэн хянах боломж бүрдээгүй ч зарим байгууллагууд салбарын нэгдсэн мэдээллийн системээр бүртгэл, хяналтыг хэрэгжүүлж байна.

Цахим системээр удирдлагын хяналт хэрэгжсэнээр торгуулийн төлөлтийн байдал, эрх бүхий албан тушаалтны ажлын хариуцлага, орлого бүрдүүлэлт, дараагийн шатны арга хэмжээ авах зэрэгт нөлөөлөх сайн талтай байна.

Байгууллагууд өөрийн салбарын онцлогт тохирсон нэгдсэн мэдээллийн системийг ашигладаг бөгөөд тус системээрээ дамжуулан хяналт хэрэгжүүлж, торгууль тавьсан эрх бүхий албан тушаалтнууд тухайн торгуулийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын хэмжээнд нэгдсэн хяналтын систем бүрдээгүй байна.

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна

Г.2.1.Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулалт хангалтгүй байна

Аудитын нэгдсэн судалгаагаанаас харахад: Аймгийн хэмжээнд 2023 онд 1,632.2 сая төгрөгийн, 2024 онд 1,587.5 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй торгуулийн мэдээллийг байгууллагаар нь ангилан Хавсралт №1-ээр харуулбал:

Хавсралтаас харахад байгууллагууд 2023 онд ногдуулсан торгуулиас хугацаа хэтэрсэн 203.7 сая төгрөг, 2024 оноос 355.1 сая төгрөг нийт 558.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийг бүрэн төлүүлээгүй байна. Энэ нь Зөрчил шалган

шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1¹¹, 7.5 дугаар зүйлийн 8¹² дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Төлөгдөөгүй үлдэгдэл 558.5 сая төгрөгийн торгуулийн дүнгээс:

- 2023 оны ГХБХБГазрын 10,0 сая төгрөгний торгуулийг шүүхээс хүчингүй болгосон байна.
- 2024 оны Мал эмнэлэгийн газрын 4.5 сая төгрөгний холбогдогч нь шүүхэд гомдол гаргасан байна.
- Аймгийн ЗДТГазрын 30.0 сая төгрөгний торгуулийг шүүхээс хүчингүй болгосон бол 30.0 сая төгрөг шүүхийн шатандаа байна.
- Цагдаагийн газар 2023 оны 9 сард 10 хүний 1,5 сая төгрөгний бэлэн бус торгуулийг шүүхийн журамаар төлүүлсэн, 2024 оны төлөгдөөгүй 265.5 сая төгрөгөөс 50.0 сая төгрөгийн торгууль бүхий 5 холбогдогч шүүхэд гомдол гаргасныг шүүхээс шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж 1 жилийн дотор хувааж төлөх шийдвэр гаргасан, дээрх 50.0 сая төгрөг болон 3 холбогдогчийн 15.0 сая төгрөг нийт 65.0 сая төгрөгийн төлөх хугацаа болоогүй байна.

Г.2.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт хэрэгжүүлээгүй байна

Аймгийн засаг даргын 2023 оны 10 сарын 17-ны өдрийн А/661, 2024 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн А/1122 дугаартай захирамжаар “Татварын өр барагдуулах” тухай аяныг зохион байгуулсан байна. Уг аянаар аймгийн цагдаагийн газар, татварын хэлтэс, автотээврийн төвийн улсын байцаагч нарт чиглэл өгч орлого төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласан байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ биелүүлээгүй нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.14¹³-д заасантай нийцэхгүй байна.

Аймаг, сумын торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, торгуулийн орлого төвлөрүүлж буй байгууллагуудын орлогод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Г.2.3 Орлого төвлөрүүлэгч зарим байгууллагууд нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна

Тайлант хугацаанд торгуулийн орлого төвлөрүүлэх үүрэгтэй байгууллагууд нь зөрчлийн торгуулийн орлогод хангалттай дотоод хяналт хэрэгжүүлээгүй улмаас орон нутгийн төсөвт бүрэн төвлөрөөгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтан нь шийдвэрийнхээ биелэлтийг хариуцан ажиллаж байна. Харин эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийн хэрэг үүсгэсэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган

шийдвэрлэсэн зөрчилд Прокурорын байгууллагаас хяналтыг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдамжаар аймгийн Цагдаагийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ба цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтаны торгосон байдал, торгуулийн орлогын төлөлт дээр хяналт хийгдээгүй зөвхөн үндсэн үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийсэн байна.

Монгол Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргааны дотоод аудитын газраас хийсэн шалгалтаар Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан Хяналт шалгалт хийх нийтлэг журамд заасан хяналт шалгалт хийх үндэслэлийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаагүй байгаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дах хэсэгт заасан хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах зарчим алдагдсан гэсэн дүгнэлт өгсөн байна.

Г.2.4. Хөндлөнгийн байгууллагуудаас торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна

Аймгийн торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хөндлөнгийн байгууллагуудаас /Иргэн, ТББ, ОУБ, Зөвлөл г.м/ хяналт хэрэгжүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Торгуулийн орлогын төлөвлөлт үндэслэлгүй байна.
2. Ногдуулсан торгуулийн орлогоос 2024 оны эцсийн байдлаар 3 байгууллага 519.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
3. Зарим сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зардал хуваарилж батлаагүй байна.
4. Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан зардлын зарцуулалт зохих үр дүнг өгсөн байна.
- 5.Хүү, торгуулийн орлого бүрдүүлэхтэй холбоотой хуулийн зарим заалтууд уялдаагүй байна
6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна
7. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.
8. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга танаа:

1. Торгуулийн орлогыг төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллах;

Аймгийн Засаг дарга танаа:

1. Торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх, он дамжсан авлагыг барагдуулах талаар эрх бүхий байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;
2. Сумуудад торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөх талаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах;

Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Татварын газар-т:

1. Хууль, тогоомжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх;

Хавсралт №1

Торгуулийн орлогын нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он					2024 он				
		Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс		
				Төвлөрсөн	Илүү	Дутуу			Төвлөрсөн	Илүү	Дутуу
1	Улсын бүртгэлийн хэлтэс	5,400,000	166	5,400,000	-	-	4,935,000	116	4,935,000	-	-
2	Боловсролын газар	70,000	2	70,000	-	-	-	-	-	-	-
3	Баян-Өлгий дэх гаалийн газар	35,200,000	89	35,200,000	-	-	47,278,216	148	47,278,216	-	-
4	Баян-Өлгий дахь Онцгой байдлын газар	1,300,000	18	1,300,000	-	-	13,950,000	17	13,950,000	-	-
5	ГИХГ-ын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	35,750,000	88	35,770,000	20,000		21,180,000	58	21,180,000	-	-
6	Баян-Өлгий аймаг Нийгмийн даатгалын газар	5,400,000	8	5,400,000	-	-	3,000,000	6	2,700,000	-	300,000
7	Баян-Өлгий аймаг Статистикийн хэлтэс	600,000	12	550,000	-	50,000	50,000	1	-	-	50,000
8	Баян-Өлгий аймгийн Автотээврийн төв	18,380,000	142	18,380,000	-	-	23,960,000	204	23,710,000	-	250,000
9	Соёл, урлагийн газар	200,000	2	200,000	-	-	700,000	3	700,000	-	
10	Мал эмнэлгийн газар	650,000	5	650,000			5,600,000	4	1,100,000		4,500,000
11	Татварын газар	98,099,388	50	91,490,095		6,609,293	72,649,293	51	49,587,164		23,062,129
12	МАНУТХГХ Захиргаа					-	500,000	1	500,000	-	-
13	Аймгийн ЗДТГазар	9,800,000	9	9,800,000	-	-	107,350,000	18	46,838,000	-	60,512,000
14	Хүнс хөдөө аж ахуйн газар	9,500,000	19	9,500,000	-	-	13,000,000	14	12,000,000	-	1,000,000
15	Эрүүл мэндийн газар	9,100,000	23	9,100,000	-	-	33,790,000	47	33,790,000	-	-
16	ГХБХБГазар	37,000,000	26	27,000,000	-	10,000,000	6,525,000	14	6,525,000	-	-
17	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	4,500,000	2	4,500,000	-	-	7,250,000	4	7,250,000	-	-
18	Байгаль орчны газар	130,486,000	33	94,430,000	-	36,056,000	79,967,000	58	79,967,000	-	-
19	Цагдаагийн газар	960,800,400	30,367	809,772,200	-	151,028,200	1,146,594,500	19,688	881,125,000		265,469,500
Нийт		1,362,235,788	31,061	1,158,512,295	20,000	203,743,493	1,588,279,040	20,452	1,233,135,381		355,143,629

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ :



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

5 дугаар баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83129

Утас/Факс: (976) 7042 3377,

Цахим шуудан: contact@bayan-olgii.khural.mn,

Цахим хуудас: www.bayan-olgii.khural.mn

2025.08.15 № **02/229**

танай _____-ны № _____-т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нэмэлт тайлбар санал байхгүй болно.

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



8325050269



МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603
E-mail: info@bo.gov.mn/
<http://www.bayan-olgi.gov.mn/>

2025. 08.15 № 1-01/1230

танай _____-ны № _____-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт
зарцуулалт” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Нэмэлт саналгүй болно.



Е.ЗАНГАР

8325031592

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ :



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/20

Өлгий

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Д.Назгүл)-д үүрэг болгосугай.

3.Аудитын тайланд тусгагдсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Д.Назгүл)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т даалгасугай.



Ж.АЙГҮЛ

832501000040